


Riskland



“Эрсдэлийн арал” тоглоомын аргыг ашиглах гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт

“Эрсдэлийн арал” бол гамшгаас урьдчилан сэргийлэх талаар суралцах тоглоом юм.

Ямар үйлдэл нь гамшгийн хохирлыг бууруулах эсвэл гамшигт өртөмтгий байдлыг нэмэгдүүлэхийг ойлгоход тань туслах мессежийг хүргэдэг.

Тоглоом тоглохдоо та урагш эсвэл хойшлох зааврыг дагах болно.

Мөн та асуултын тэмдэг/сармагчингийн байгаа нүдэнд очихдоо асуултын карт дээрх гамшгаас урьдчилан сэргийлэх асуултуудад хариулах ёстой.

Тоглоомын дүрэм

Тоглоомын баг: 2 хүнээс дээш байх (багт хуваагдаад ангийн бүх хүүхэд оролцох боломжтой.)

Хэрэглэгдэх зүйлс: Тоглоомын хөлөг, шоо, морь (зоос, вандуй, чулуу гэх мэт тоглогчдыг төлөөлж чадах бүх зүйлийг ашиглаж болно.), асуултын карт 24ш, гэнэтийн карт 24ш (энэхүү 2 төрлийн картыг тоглоом эхлэх үед холих ёстой).

Тоглоомын арга: Бүх морьдыг гараан дээр байрлуулна. Шоог ээлжлэн хаяж, буусан нүдний хэмжээгээр урагш нүүнэ.

Бариа (65дугаартай нүд)нд түрүүлж очсон хүн ялагч болно

Хэрэв барианд ойртсон үед шоог хаяхадбуусан нүдний тоо одоогийн байгаа байрлалаас бариа хүртэлх нүдний тооноос их байх тохиолдолд эхлээд бариа хүртэл нүүгээд үлдсэн хэмжээгээр ухарч нүүнэ.

Жишээ нь, хэрэв одоогийн байрлалаас бариа хүртэл 3 нүд байхад хаясан шооны нүдний 7 буусан бол урагш 3 нүд нүүж барианд очсоны дараа 4 нүд ухарч нүүнэ гэсэн үг.



Асуултын карт: Асуултын талбарт очвол өрсөлдөгчөөсөө асуултын картны дээд талд байгаа карт дээр бичсэн асуултыг асуугаарай.

Хэрэв зөв хариулбал дахин нэг боломж олгоно.



Гэнэтийн карт: Улаан нүдэнд ирвэл гэнэтийн картан дээрх зааврыг дагана уу.

Даалгаврын заавар бичигдсэн нүдэнд очволтэрхүү даалгаврыг гүйцэтгэнэ.

Жишээлбэл, хэрэв та 13-р нүдэнд ирсэн тохиолдолд олон мод тайрсан тул тосгоны гамшигт өртөх магадлал нэмэгдэх тул гарааны талбар руу шилжих.

